

“ МОНГОЛ ШИЛТГЭЭН ” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 04 дүгээр сарын 30 өдөр

№ 23 / 01.

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“ МОНГОЛ ШИЛТГЭЭН ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 04-р сарын 30-ны өдрийн 14.00 цагт УБ хот Баянзүрх дүүрэг 20-р хороо Гачуурт тосгон компанийн өөрийн байрнд хуралдав.

Хуралд:

“ Монгол шилтгээн” ХК –ийн хуралд хувьцаа эзэмшигч:

1. ТТ Транс ХХК 3532125 ширхэг
2. Ч.Амарбаатар 3 323 000 ширхэг
3. Ж.Баатар 2 ширхэг
4. Д.Янжмаа 5 ш
5. С.Уранчимэг 10 ш
6. Д.Отгон 5ш
7. Ж.Сарангэрэл 10
8. М.Довууч 5ш
9. Н.Энхтунгалаг 25ш
10. А.Чимэдлхам 10ш
11. С.Долоонбаяр 1 ш
12. М.Отгонбаяр 1ш нар тус тус оролцов.

Хурал зохион байгуулах комисс хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хийж компанийн нийт гаргасан хувьцааны саналын эрхтэй хувьцааны тоог **6.855. 198** ширхэг хувьцаагаар тогтоож хурлын ирц 68.5 %тай байгааг мэдээлж компанийн тухай хуулийн 69.1-д заасны дагуу хурлыг хүчин төгөлдөрт тооцож хурлыг эхлүүлэхийг тооллогын комисс зөвшөөрөв.

Хурал 14 цаг 10 минутад эхлэв.

✓ Хурлын дарга Ч.Амарбаатар хурлыг нээж үг хэлэв.

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд та бүхэнтэй нээлттэй ярилцаж санал бодлоо хуваалцахын зэрэгцээ өнгөрсөн жилд хийсэн ажлын бүтээмж, үйл ажиллагааны болон санхүүгийн талаар дүгнэж санал бодлоо илэрхийлэх бусад хэлэлцэх асуудлын хүрээнд нээлттэй боломж олдож байгаад баяртай байна.

Цаашидаа компанийхаа төлөө тавьсан зорилго зорилтоо хэрэгжүүлж ажиллах үүднээс хамтарч ажиллах, компанийн ашиг орлогыг нэмэгдүүлэх алдагдалыг бууруулах тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй байгааг нийт хуралд оролцож буй компаний эрх бүхий албан тушаалтнуудад өөрийн зүгээс байр сууриа илэрхийлэв. Ингээд хурал нээсэнийг мэдэгдэж хурлын дэгийг уншиж танилцуулав.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

- Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.
- Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах
- ТУЗ-ийн гишүүдийг сонгох
- Компанийн өр авлагыг хэлэлцэх тухай
- Их хэмжээний хэлцэл батлах тухай
- Өрийг хувьцаанд хөрвүүлэх
- Сонирхолын зөрчилтэй хэлцэл батлах тухай
- Тэргүүн ээлжинд худалдан авах эрх олгох тухай
- Компанийн дүрмийн өөрчлөлт
- Бусад асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

Тус компанийн 2022 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, жилийн эцсийн санхүүгийн тайлан, 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг гүйцэтгэх захирал М.Ган-Эрдэнэ танилцуулах талаар төлөвлөөд байна. Зөвшөөрч байна уу .

- Хувьцаа эзэмшигчид зөвшөөрөв.

СОНССОН НЬ:

Хурлын хэлэлцэх асуудлын дагуу 2022 онд хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланг М.Ган-Эрдэнэ товч танилцуулав. Үүнд:

Үйл ажиллагааны чиглэлээр:

- Цаашид бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ орлого нэмэгдүүлэх тал дээр ихээхэн анхаарч ажиллана.

Барилгад засвар тохижилт үйлчилгээ хийх:

- Барилгын засвар болон дээдрийн ажлуудыг хэсэгчлэн хийх

- **Үйлчилгээний стандарт харилцаа хандлагын талаарх сэдэвчилсэн төрөл бүрийн сургалтыг зохион байгуулах**

Санхүү мэдээ борлуулалт

- Санхүү нийгмийн даатгалын, татварын тайлангуудыг цаг хугацаанд нь гаргаж хүргүүлэх
- Байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажиллана.
- Цаашид “Монгол шилтгээний барилгад засвар үйлчилгээ хийх томоохон ажлууд байна гэж Гүйцэтгэх захирал М.Ган-Эрдэнэ товч танилцуулав.
- Хуралд оролцогч тус бүрт хурлын материал, танилцуулга тараасан.

1 дэхь хүндрэл: Санхүүгийн зохицуулах хорооны Шийдвэр гаргагчид нь манай асуудлыг шийдэж өгөөгүй, албан бичиг ч өгөөгүй, Хувьцаа эзэмшигчдийн хурал руу буцаасан. Энэ хурал дээр ахин асуудлаа ярилцаад материалаа ахин өгнө, шийдээгүй тохиолдолд авлигатай тэмцэх газарт ч хандаж болох юм. Төрийн албан хаагчид асуудалд их хойрго, авлигаар л шийдэх хандлагатай байна.

2 дахь хүндрэл: Ковидын 3 жилийн хугацаа Монгол шилтгээнийг сүйрүүлсэн. 3,5 га газар зөвхөн нэр л үлдсэн. Жил бүр додомдоод засвар хийдэг байсан боловч Цоожтой 3 жил байсны улмаас байгал өөрийхөө хийх ажлыг хийсэн буюу Шилтгээн элэгдэж усанд автан чийгтэж мөөгөнцөртөн, нурж унаж эхэлсэн байгаа.

Би Хувьцаа эзэмшигчдийн хуралд байнга 2 асуудлыг тавьдаг.

1. Компаний өрийн асуудал. Отгонбаатар захирлын ХК байгуулагдахаас өмнө тавьсан өр зээлийн асуудлыг анх хувьцаа авсан өдрөөсөө эхлэн бүх гишүүдийн хуралд энэ өр зээлийг яах вэ гэж ярьж ирсэн
2. МШ ХК-ий шилтгээний концепцийг юу гэж гаргах вэ гэж ярьдаг боловч дэмжигддэггүй. Харин 2021 оны хурлаар өрийг хувьцаагаар солих асуудлыг шийдэхээр болсон боловч Засаг шийдэж өгсөнгүй. Иймд энэ хурлаар тэр өрийг хувьцаагаар солих асуудлыг ахин шийдүүлнэ. Мөн хөгжлийн ямар загвараар энэ компани хөгжих вэ гэдэг тухай ярьмаар байна. Монгол Шилтгээнд ирээдүй бол байгаа. Ирээдүй нь тэнд барьсан барилга бус тэр байрлал. Баянзүрх хайрханы бэлд Туул голын эрэг дээр байгаа тэр байрлал нь хамгийн том зүйл нь. Олон сайхан шоунууд болдог болсоны дотроос Плей тайм шоу нь Монголын том бренд болтлоо хөгжсөн. Тэрэн дээр үндэслэн хурим найр хийдэг 400-500 хүн багтах зал хийж чадвал орлого олох боломж байна. Хувьцаа эзэмшигч Таван Толгой компанитай бид олон дахин ярьсан. Өрийг хувьцаагаар солих энэ асуудал шийдэгдээгүйн улмаас хөрөнгө оруулалт хойшилогдож байгаа сул тал байна. Хөгжлийн концепцыг хойшлуулж болно. Компани ямар ч байсан өргүй болохын төлөө нэмж 8 саяын хувьцаа гаргана, нийт хувьцаа 18 сая гаруй болж байна.

Ариунсайн: Хөрөнгийн бирж өөрчлөлт оруулахаар албан ёсоор тушаалаа гаргаад СЗХ дээр гацаад байгаа. Энд зөвхөн манайх гэлтгүй олон газар ийм байдалтай бна.

ХЭ.....эр :Санхүүгийн зохицуулах хороо албан ёсоор баталгаажуулж байж л болно л доо. Хувьцаа эзэмшигчид буюу бид хэд яваад очиход болох юм. Энэ төрийн албан хаагч ингээд шийдвэр гаргахгүй байна гээд бид ТВ дуудаад яваад очиход үр дүнтэй байх талтай. Та очихоор юм нэхээд байж магадгүй.

Амарбаатар: Хамгийн том хүч бол та нар юм.

Отгонбаатар: Яг юм нэхэхээсээ илүү шийдвэр гаргаж чадахгүй байгаа мэргэжилтэний алдаа байх.

Амарбаатар: Хөрөнгийн биржийн гаргасан тогтоол, тушаал нь байгаа. Ганцхан энийг баталгаажуулах асуудал нь Санхүүгийн зохицуулах хорооны асуудал дээр гацсан байна.

Жаргалсайхан: Төрийн албан хаагчид бээлий сольж байгаа шиг өөрчлөгддөг. Асуудлаа мэдэхгүй, халагдчих болов уу гэсэн айдсаас болоод шийдвэр гаргахгүй байгаа, Ямар үед гаргадаг вэ гэхээр энгийн хурлын шийдвэр материалыг шийдээд иймэрхүү асуудал дээр шийдвэр гаргачихаар чи тэнд ямар ашиг сонирхолтой юм бэ гэж дараад байнаа гэсэн асуудал байгаа. Тэгэхээр гол үндсэн асуудлаа зөв тавих нь энэ компаний эрх барих дээд байгууллага нь ХЭ-ийн хурал нь. Энд шийдвэр гаргачихсан байхад СЗХ -ы 1 бизнес хийж үзээгүй мэргэжилтэн энэ компаний хувьцаа эзэмшигчидийн шийдвэрийг зөв буруу гээд шүүгээд сууж байдаг бол утгагүй асуудал. Тэнд ганц үүрэг байгаа нь жижиг хувьцаа эзэмшигчидийн эрх ашиг хөндөгдөж байна уу гэдгийг л харах ёстой. Тэд компани өргүй болж байгаа нь цаашид өргөжөөд явах ёстой байтал өнгөрсөн жил гаргасан шийдвэрийн гүйцэтгэл явагдаагүй байна гэдэг нь тэр хэмжээгээр компаний үйл ажиллагааг зогсоож байна. Уг нь ХК-ийг майн засаглалтай гэж ярьдаг, гэтэл хамгийн эмзэг болж байгаа юм нь энэ засаглалыг СЗХ барьчихаад ингэ тэг гээд суугаад байгаа нь ТӨ компаниудаа хянадаг байж магадгүй. Харин нээлттэй явж байгаа ХК ий хувьд шийдвэрлэх л хэрэгтэй байгаа.

Ариунсайн: Ер нь зохицуулалтын үйлчилгээ үзүүлдэг байгууллага. Өөрсдийгөө хянадаг шалгадаг байгууллага гээд ойлгогчихсон

Амарбаатар: Энэ ХБийн тушаалын 3 дээр Монгол Шилтгээний өөрчлөлт орсон мэдээллийг СЗХ-ы шийдвэр гарсны дараа олон нийтэд хүргэж холбогдох мэдээллийн санд өөрчлөлт оруулахыг Бизнес Хөгжлийн Газар Хаш-Эрдэнэд даалгасугай гэсэн байна. Тушаалыг бүтнээр нь уншъя.

Ийм тушаал нь байгаа болохоор 5,6-р сардаа багтаагаад шийдүүлээд авчихвал хөрөнгө оруулалт хийх боломж байна гэж үзэж болох юм

ХЭэм : Энэ өр нь Тэр Отгонбаатарын өр юм уу? Хуучин хувьцаануудын ханш буух уу?

Амарбаатар: 10-аад жил шүүхдээд зөндөө явсан. Өртэй компанийг бүртгэсэн МХБирж буруутай юу үгүй юу гэдэг асуулт байгаа. Голомтын хувьд өөр аргагүй зөв, дампууруулах асуудал тавиад хөрөнгө хураах шатанд очсон, дүүргийн шийдвэр гарчихсан цаазын тавцанд байсан учир тэр өрийг төлж компаниа авч үлдсэн. Одоо тэр төлсөн мөнгөө хувьцаа болгож гаргаж ирэх асуудал яригдаж байна. Ноднин зөндөө ярьсан, татан буулгах уу? ХХК болгох уу? Өрийг хувьцаагаар солих уу гээд. Ханш унана гэж яриад байгаа нь монголчуудын хамгийн том алдаа. Энийг босгохын төлөө л ажиллах хэрэгтэй. Компаний тэдэн хувь гэдэгээс илүү компани хөгжөөд хувьцааны үнэ өсөөд явах нь чухал. Компаний шийдвэр гаргах түвшинд очино гэвэл хүрээд ир, Welcome, хамтраад явъя гэж байна. Дэлхийн жишигт тэдэн ширхэг хувьцаатай гэж ярьдаг болохоос тэдэн хувь гэдэг ойлголт бол

нийтэд байхгүй. Хувьцааны үнэ л өсөж байх ёстой болохоос.. Өөр өнцгөөс харж хөгжүүлэх тухай ярьж байна. Өөр асуулт байхгүй бол дараагийн асуудал руу оръё.

Отгонбаатар: Бүх хүнд хувьцаа худалдаж ав гэж боломж олгож байна. Энэ хувьцааг авч Хувьцаа эзэмших, өрөөс төлөлцөөч гэж санал гаргаж байна. Ганцхан энэ хүн л энэ эрсдэлийг зөвшөөрөөд мөнгөө хийсэн байна. Гэхдээ өөрийхөө төлөө биш компаний төлөө өөрөө эрсдэл үүрч өчнөөн жил явсан байна.

ХЭэм: Одоо хөрөнгийн бирж дээр зарагдаад явж байгаа гэсэн үг үү?

Амарбаатар: Эхлэхийн тулд л СЗХ-ий зөвшөөрөл дутаад гай болоод байна.

Жаргалсайхан: Энэ хүн гаргасан мөнгөө хувьцаа болгоод 290 төгрөгөөр нь зарна шүү дээ. Зарахаар нь бусад хүмүүс 2 дахь зах зээл дээр тэрийг нь худалдаж аваад явах нь нээлттэй асуудал.

Ариунсайн: Өрийг хувьцаагаар солихтой холбоотой компаний тухай хуулинд тэргүүн ээлжинд худалдаж авах эрх үүсдэг.

ХЭэм: Нэмж гаргасан хувьцаанаас бид яаж худалдаж авах билээ? Хөрөнгийн биржээс хуучин аргаараа авах юм уу?

Отгонбаатар: Журмын дагуу хүсэлтээ өгөөд авна.

Амарбаатар: Монгол Шилтгээнийг юу байгаа юм гээд очоод харахаар балгас л болсон байна. Миний хувьд мөнгөө оруулсан, дээр нь 2,5 тэрбум өрий нь төллөө. Энэ компанийг аврах гээд л яваад байна. Дампуурчихвал бүгд zero болж бүх юм байхгүй болно. Компанийг удирдаж байсан хүмүүс Монголын бизнесээс арчигдах гээд байна. Дампууруулаад худалдаад авчихвал энэнээс хямдаар шийдэгдэх байх. Гэхдээ ХК-ийг дампууруулсан эзэд гэхээр ТУЗ-ийн дарга гишүүд орно, 1 компанийг дампууруулчихаад дараагийн компаний ТУЗ-д ороод явж болохгүй биз дээ. Гэтэл бидэнд маш их төлөвлөгөө, мөрөөдөл, зорилго байдаг. Энийхээ төлөө явахын тулд энэ компанийг дампууруулж болохгүй гээд мөнгөө хийж байхад засаг асуудлы нь шийдэж өгөхгүй байна.

ХЭ.....эр: Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг зөрчигдөж байна гээд комисс байгуулаад явж болох юм. ХБ зөвшөөрчихсөн энэ компанийг цаашид хөгжүүлэх ажлыг нь дэмжих ёстой юм. Төр бол үйлчилгээ үзүүлэх ёстой. Тэрнээс хүнд суртал гаргаад хойшлуулаад гацаагаад байж болохгүй. Гэтэл төрийн банкны хувьцааг гэрлийн хурдаар хийж байгаа. Уг нь адилхан шүү дээ.

Амарбаатар: Монгол Шилтгээний хэрмийг нураагаад 3 давхар жилийн 4 улиралд ажилладаг зочид буудал барихаар зургий нь гаргаад явж байна. Доор нь эмнэлэг үйлчилгээ, сувилал байж болно. 48 том өрөөнүүд гарна, Хэлбэрий нь хадгалж үлдэнэ. Одоо байгаа рестораныг янзлаад хажууд нь том хүлээн авалтын зал, хурлын зал гм

ХЭэм: Өмнө нь яригдаж байсан асуудлууд яригдаад байна

Амарбаатар: Өмнө нь өрийг хувьцаагаар солих тухай яригдсанаас энэ төсөл яригдаагүй. Энд мөнгө зарж энэ төсөл хийгдэж байна. Хөгжихийн тулд юм хийх ёстой. Гадна дотны хүмүүст танилцуулах хэрэгтэй. Хувьцааны асуудал шийдэгдчихвэл дараагийн хөгжлийн асуудалдаа ормоор байдаг. Газар,

байрлал чухал. Баянзүрх хайрхан Туул гол. Ямар ч нар үздэггүй тэр хэрэмэнд элдэв хар сүнс бүх муу муухай болгон шингэчихсэн байна. Би өөр өнцгөөс ярьж байна.

ХЭ.....эр: Хурлаас гарах шийдвэр чухал. Бүгд 100% дэмжиж байна, энэ хурлаас гарах шийдвэрийг хэн ч өөрчлөх эрх байхгүй. Болохгүй бол тэр албан тушаалтныг авлигатай тэмцэх газарт өгч болно. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас том ямар байгууллага байна?

Амарбаатар: Та их зөв ярьж байна. ХЭХурлаас гаргасан шийдвэрийг бүртгэх л үүрэгтэй болохоос гацаадаг байж болохгүй. Эрх барих дээд байгууллага нь ХЭХ гэж заачихаад, тэр шийдвэрийг биелүүлэх гээд бид явж байна.

ХЭэм: ХЭХ –аас гаргасан шийдвэрийг одоо болтол биелүүлээгүй тэр СЗХ –ы холбогдох албан тушаалтныг арга хэмжээ авч асуудлыг богино хугацаанд шийдүүлэх тийм шийдвэр гаргая.

Жаргалсайхан: 276 ХЭ байна. Ажлын хэсэг байгуулаад, ийм асуудалтай олон компани байгаа, нийлээд явж болох юм. Хуулиас дээш гарсан олон журмууд байдаг, Шалтаг шалтгаан мундахгүй

ХЭэм: ТУЗ-ын гишүүд хуралдаа идэвхтэй оролцох хэрэгтэй. 9-өөс 5 нь ирсэн байна

Амарбаатар: Гэрүүд болон хэлбэр хөөсөн мөн чанараасаа хол байрууд цэвэрлэхээс эхлээд зочид буудлын энгийн өрөөнүүдэд хийгддэг ажилууд бүгд маш хүндрэлтэй хийгддэг. 3 давхар зочид буудалд байдаг өрөөний тооноос тэр тарсан байруудын тоо цөөн байгаа. Дотор зочид буудлын 12 байрыг цэвэрлэх хугацаанд 2 байр л цэвэрлэх жишээтэй. Ямар ч цонхгүй нар тусдаггүй байранд муу юм шүглэдэг юм байна.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай хэмээн үзсүгэй.
2. “ Монгол шилтгээн” ХК-ийн 2022 онд алдагдалтай ажилласантай холбогдуулан ногдол ашиг хувиарлахгүй байхаар тогтоосон ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулав.
3. 2022 онд бизнесийн үйл ажиллагааг эрчимжүүлж, ашигтай ажиллах талаар идэвх санаачлага гарган ажиллахыг Гүйцэтгэх захирал М.Ган-Эрдэнэд даалгасугай.
4. ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай саналын хуудас тараасан болно.

ТУЗ-ийн ердийн гишүүдэд

1. Ч.Амарбаатар
2. М.Ган-Эрдэнэ
3. Г.Ганчимэг
4. Д.Давгадорж
5. Г.Мөнхбилэг
6. Б.Билгүүн

ТУЗ-ийн хараат бус гишүүд

1. Ж.Жаргалсайхан
2. М.Отгонбаатар
3. Д.Чанцал нарыг нэр дэвшүүлж санал хураалт явагдлаа .
4. Өрийг хувьцаанд хөрвүүлэх төсөл батлах тухай.

Хурлын дарга Ч.Амарбаатар өр хэрхэн үүссэн талаар товч тайлбар хийлээ.

- Компанийн 2 500 000 000 төгрөгийн өрийг хувьцаагаар солихоор нэмж гаргасан хувьцааг хувьцаа эзэмшигч нарт тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхийг эдлүүлэх талаарх асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв.

Хурал хэсэг засварласаны дараа Тооллогын комиссын дарга А.Ариунтунгалаг, гишүүн Ю.Батжаргал нар саналын хуудасыг тоолж танилцуулав.

Хурал зохион байгуулах комиссын дарга А.Ариунсайн хурлаас гарсан шийдвэр, тогтоолын төслийг уншиж танилцуулснаар хурал амжилттай өндөрлөв.

Хурал 17.30 –д өндөрлөв.

Хурал удирдсан хурлын дарга:

Протокол бичсэн:



..... / Ч.Амарбаатар /

..... / А.Ариунсайн /